

## ХАВСРАЛТ

### Ц.Дамдинсүрэнгийн захиас

Ардын уран зохиолч, академич Ц.Дамдинсүрэнгийн мэндэлсний 100 жилийн ой тохиож байгаа энэ өдрүүдэд түүний 50-иад жилийн тэртээ хүүхэд, залуус, сэхээтнүүдэд хандаж, тус тус хэвлэлд бичиж үлдээсэн захиас зөвлөмжийг сөхөн үзэхэд сонин, бас сургамжтай учраас бид түүний агуулгыг товчлон өгүүлье.

Академич Ц.Дамдинсүрэн 50 насныхаа ойн үеэр ойн үеэр “Пионерийн үнэн” сонинд “Үр хүүхэддээ хэлэх үг” гэсэн нэрээр таван зүйлийн захиас бичжээ.

Нэгдүгээрт, хүүхэд багачуудын зан суртахуунд анхаарч, “залхуу хойрго, хичээлгүй муу явдал, худал хэлж, зальхай явдал үүсгэх, ажил хөдөлмөрөөс зугатаж, арга заль гаргах нь нэр муутай болгодог” гээд нэр төрөө цэврээр хадгалж явахыг захижээ.

Нөхдөө хайрлаж хүндэтгэдэг, бусдад тусархаг, нөхөрсөг, ажилч, эрдэм номтой, хичээлтэй явах нь чухал гэжээ.

Хоёрдугаарт, хүүхэд багачуудын өвлөж авах хөрөнгийн талаар өгүүлжээ.

Эцэг эх, үр хүүхэддээ урьдын адил авдрандаа алт мөнгө үлдээх бус, харин өв хөрөнгийг бүтээх хөдөлмөрийн чадвартай болгон хүмүүжүүлэхийг чухалчилдаг, “өөрөө ямар ч ажил хийхгүй бусдын бүтээсэн ажлын шүүс шимийг хувалз шиг сорж, хүний хүзүүн дээр сандайлж амьдрахаас илүү муухай юм ертөнц дээр байхгүй” гэж зөвлөөд үнээ саадаг хүүхдийн өөртөө болон улсдаа ямар ач тус хүргэдгийг жишээлэн ярьсан байна. Тэгээд бүтээлч хөдөлмөр үл хийгчдийг жигшиж, үнэнчээр ажилладаг хөдөлмөрч заншлыг өв болгон үлдээх нь зүйтэй гэжээ.

Гуравдугаарт, манай ард түмэн эрх тушаалаас эрдэм билгийг илүү эрхэмлэж ирснийг дурьдаад, хүүхэд багачуудад эрдэм номд шамдан сурахын ач холбогдлыг тайлбарлаж, “зөвхөн олонд хүндлэгдэхийн төлөө эрдэм сурах биш, харин олны хэргийг бүтээхийн төлөө эрдмийг сурах хэрэгтэй” гэж захисан байна.

Дөрөвдүгээрт, урьдын хүүхэд багачуудын амьдралтай жишиж үзвэл, эрдэм мэдлэгтэй, ажилтай, шударга хүн болж, сайхан амьдрах бололцоо байгааг дурдаад, бас эрүүл чийрэг өсөх ёстой. Үүний тул “биеийн тамираар тасралтгүй оролдоцгоо. Биеийн тамирын хичээл бол эрүүл чийргээр өсөхийн чухал нөхцөл болно” гэжээ.

Тавдугаар, эрдэм сурч эрүүл чийрэг, ажилч хүн болохын учир холбогдлыг Монгол улсаа улам бататган хөгжүүлж мандуулахын төлөө юм. Гэхдээ бид дэлхий дахины (өөрөөр хэлбэл, бөмбөрцөг Г.Л) дотор багтаж байдгийг мартаж болохгүй. Дэлхий дахины найрамдлын хэрэгт идэвхитэйгээр оролцож байх хэрэгтэй. Эх орондоо хайртай, орон бүхний найз нөхөддөө хайртай нөхөрсөг байхыг эцэст нь захижээ.

Даяаршлын өнөө үед Монголын хүүхэд багачууд эрдэм номд шамдан сурч боловсрохын зэрэгцээгээр даян дэлхийн улс түмний үе тэнгийнхэнтэйгээ хөл нийлүүлж, мини парламент зохион байгуулах зэргээр улс төр, нийгэм болон урлаг соёлын арга хэмжээнд хувь нэмэр оруулж байгаа нь их эрдэмтний захиас биелж байна гэж хэлэхэд таатай байна.

1961 оны дөрөвдүгээр сард МХЗЭ-ийн Төв Хорооны “Залуучуудын үнэн” нэг дугаарынхаа ихэнх нүүрийг “Ахмад үеийнхний алтан сургаалаас” нэрийн дор тухайн цагийнхаа алдар нэртэй төрөл бүрийн ажил мэргэжлийн 10 гаруй хүний

сургамж зөвлөмжийг нийтэлсний дотор эрдэмтэн зохиолч, профессор Ц.Дамдинсүрэнгийн хэлсэн үгийг “Хүн хөдөлмөр хоёрыг хүндэтгэж сур” гэсэн гарчигтайгаар нийтэлжээ.

Энэ нь их эрдэмтний хоёр дахь захиас юм. Үүнд, залуучуудын хөдөлмөрлөх, сурах хүсэл оргилж байгаад сэтгэл хангалуун явдгаа эхэлж өгүүлээд ажил үг хоёр хүний чанарыг харуулна. Ажил үг хоёрт хайнга хандаж болохгүйг анхааруулжээ. Залуусын дотор хотод суух, хөнгөн ажилд дуртай хүмүүс байгааг шүүмжлээд, бас тэдний төрөлх авъяас хүслийг хайхрахгүй, сонирхолгүй сургуульд тулган оруулах, дургүй ажилд хүчлэн томилох зэрэг тухайн үеийнхээ нийгэм, улс төрийн ажлын арга барилыг буруушааж, энэ нь залуу хүмүүсийн ажлын хариуцлага, сонирхлыг сулруулах шалтгаан болж байна гэж үздэгээ илэрхийлсэн байна.

“Залуу хүн бүр дуулгавартай, ах зах хүний үгийг сонсдог, дагадаг байх. Тэгэхдээ заавал өөрөө шүүж боддог толгойтой байх хэрэгтэй юм” гэсэн нь өнөөгийн нийгмийн эх захаа алдсан зарим залуусын байдлыг урьдчилан харсан сануулга гэж хэлэхэд буруудахгүй. Тэгээд ч төр засгийн удирдлагад хандаж “залуу хүмүүсийн авъяас дурыг дагуулан гадаад хэл сурах, сургах явдлыг урамшуулмаар” гэж санал тавиад залууст хандаж “гадаад хэлгүй хүн худгийн мэлхий шиг болж хоцорно” гэж зүйрлэн өгүүлжээ.

Академич Ц.Дамдинсүрэнгийн гурав дахь захиас нь сэхээтнүүдэд зориулж үг хэлнэ үү? гэсэн “Хөдөлмөр” сонины асуултад түүний өгсөн хариулт юм.

Их эрдэмтэн дан оюуны хөдөлмөр бус, оюуны болон биеийн хөдөлмөрийн сэхээтэн, болох, ялгаврыг арилгахыг хүсээд манай албан хаагчид үндсэн хуульд бичигдсэн “төвлөн удирдах ардчилсан ёсыг гүнзгий зөв ойлгоосой” гэж сануулсан байна.

Албан хаагчдын дотор ялангуяа аймаг, сумын захиргааны газруудад “төвлөн удирдах” гэдэг үгийг томоор бичсэн, “ардчилсан” гэдэг үгийг жижгээр бичсэн юм шиг ойлгодог хүн цөөнгүй байдаг.

Тийм хүмүүс захирах тушаахыг мэдэхээс биш, ард түмэндээ үйлчлэхийг мэдэхгүй, хүнд сурталтан болох гэж байна гэсэн нь хэдийвээр нийгмийн өөр харилцаанд байх үед хэлсэн үг боловч ардчилал гэх хий ярих дуртай өнөө үеийн төрийн түшмэл нарын дутагдлыг хэлсэн мэт өгүүлжээ.

Ажил хэргээ ард олонтойгоо зөвлөхгүй, дур зоргоороо туйлдаг зарим захирах тушаалын хүмүүсийн ажлын арга барилыг буруушаахын зэрэгцээ сэхээтнүүд нөхөрсөг харилцаатай байж, бие биедээ туслан дэмжиж, хүчээ нэгтгэхийн оронд ганц ганцаараа товойж гарахыг чармайх явдал үзэгдэж байна гэсэн нь монголчуудын “тамын тогооны үлгэр”-ийг шууд хэлээгүй боловч түүнд санаа зовдоогоо илэрхийлсэн хэрэг юм.

Тэгээд ололт амжилт гаргахад бие биеэ дэмжиж хамтаараа элбэж байж ард түмнийхээ хэргийг бүтээх нь хамгийн чухал гэж зөвлөсөн байна.

## Монголын ард түмэн төрийнхөө тусгаар тогтнолын төлөө хэрхэн саналаа өгсөн бэ?

1945 оны наймдугаар сарын 14-нд ЗХУ ба Хятадын хооронд найрамдал болон холбоо тогтоох хэлэлцээрт гарын үсэг зурсан юм. Энэ хэлэлцээрт Гоминдааны хятадын талаас ерөнхий сайд Сүн Цзи-Вен, гадаад яамны сайд Ван Ишц Цзе нар оролцов. Монголын тусгаар тогтнолыг хэвээр байлгах тухай гурван улсын хэлэлцээрийг ЗХУ-ын засгийн газар хятадын талд танилцуулав. Хятадын засгийн газар уг асуудалд хариу өгөхдөө “Хэрэв монголын ард түмэн нийтээр өөрийн улсын төрийн тусгаар тогтнолыг санал хураах журмаар нотлох аваас түүний тусгаар тогтнолыг Японы дайн дарагдсаны дараа одоогийн хилээр нь Хятад Улс хүлээн зөвшөөрч болох юм” гэсэн билээ.

...Крымын бага хурал ба Зөвлөлт Хятадын Засгийн газрын хооронд Монголын тусгаар тогтнолыг хүлээх асуудлаар харилцан тохиролцсоныг харгалзан БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газар өөрийн орны тусгаар тогтнолын асуудлаар бүх ард түмний санал хураах ажлыг 1945 оны 10 дугаар сарын 20-нд явуулахаар тогтоол гаргав.

Санал хураалтын ажлын бэлтгэлийг сар хүрэхгүй хугацаанд явуулах байсан нь нам, төр, олон нийтийн байгууллагаас асар их шаргуу ажил шаардагдав.

Санал хураалтын ажлыг явуулах улс олон нийтийн төв комиссыг БНМАУ-ын бага хурлын Тэргүүлэгчдийн дарга Г.Бумцэндээр даргалан байгуулав. Комиссын орлогчоор Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал, нарийн бичгийн дарга Ч.Сүрэнжав, Төв Хорооны нарийн бичгийн дарга Г.Дамба бид нар оролцов.

Санал хураахтай холбогдсон ухуулга таниулгын олон материал хуудас, ярианы сэдэв зэргийг Улаанбаатарт бэлтгэн хэвлүүлж орон нутагт түгээн тарааж, бэлтгэл ажил явагдахад улс даяар 13000 хурал цуглаан болж түүнд олон мянган малчин, ард, ажилчин, сэхээтэн оролцжээ. Төв комиссын нэр дээр хөдөлмөрчдөөс олон мянган захидал, цахилгаан ирүүлж нам төрөө нягтран хүрээлж, улсынхаа тусгаар тогтнолын төлөө саналаа өгч, түүнийг хамгаалахад хэзээ ч бэлэн байна гэдгээ илэрхийлж байв. Санал хураалтад сонгуулийн эрхтэй эрэгтэй, эмэгтэй ард иргэд оролцох ёстой байв.

Санал хураалтыг орон нутагт зохион явуулахаар Төв комиссын орлогчид тус бүр хоёр аймаг хариуцуулан явуулав.

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Цэдэнбал Увс, Ховд аймгийг хариуцан гарав. Би Өвөрхангай, Баянхонгор аймгийг хариуцан сар шахам ажиллахаар газар дээр нь очихдоо Төв Хорооноос бэлдсэн бүх ухуулга, таниулгын материал ба санал хураахад зориулан төв комиссоос бэлдсэн олон хүснэгт зэргийг авч явав.

Би хоёр аймгийн төвд санал хураалтын асуудлаар тус бүр семинари явуулав. Семинарт аймгийн намын хороо, аймгийн захиргаа, аймгийн төвийн албан байгууллагуудын удирдах хүмүүс, хариуцлагатнууд, сум нам, захиргааны дарга нар бусад хариуцлагатай хүмүүс оролцов.

Семинарт тусгаар тогтнолын төлөөний санал хураалтыг явуулах талаар Төв Хороо, төв комиссоос гаргасан тогтоол, шийдвэр, зааврыг дэлгэрэнгүй тайлбарлан ярив.

Ухуулгын ажлыг айл өрх, сум, баг, албан газраар хийх ажлын төлөвлөгөөг дэлгэрэнгүй танилцуулж, ярианы сэдэв, наах хуудас зэргийг хариуцлагатнуудад гардуулан өгөв.

Таниулгын ажлын явцыг айл нэг бүрээр орж хэд хэдэн удаа шалгах, санал хураах цаг, газар, айл өрхийг нарийвчлан тогтоохоор ярилцан тохиролцсон юм. Санал хураалтын мэдээг баг, сум, айлаас дор нь хүлээн авч үдээс өмнө дүгнэж 10 дугаар сарын 20-ны дотор багтаан Төв Комисст мэдэгдэх үүргийг биелүүлэхэд сумдын хооронд утсан холбоогүй, мэдээ зөөх машин уналгагүй, бас мэдээг нэгтгэн дүгнэх мэргэжлийн хүмүүсээр дутуу зэрэг нэн бэрхшээл тохиолдож байсныг хэрхэн давж уг ажлыг цаг хугацаанд нь багтаан явуулахыг ярилцан тохиролцсон билээ.т

Тавьсан зорилгыг хангахын тулд баг бүрт мэдээ зөөв дамжуулах өртөөг түр байгуулж, мэдээг тусгай богцонд хийж ганзагалаад 5-10 км хооронд морины хурдаар авч ирэхэд цааш дамжуулах эмээлтэй морь бэлтгэн хүн хүлээж аваад морины хурдаар дамжуулж байхаар буухиа өртөө зохиов. Бас багаас сумын төв рүү дээрх аргаар мэдээ хүргүүлэх морин өртөөний цэгүүдийг түр байгуулав. Сумын төвөөс аймгийн төврүү бол мэдээг автомашинаар авахаар ачааны ба суудлын бүх машиныг хуваарилахад аймгийн төвийн машин хүрэлцэхгүй байсан тул Улаанбаатараас орон нутагт явж байсан ачааны ба суудлын машиныг нэг өдрөөр дайчлан ажиллуулж билээ. Мэдээг шалган дүгнэхэд баг, сум, аймгийн төв дээр байсан нягтлан бодогч нарыг сампинтай нь дайчлан хуваарилан суулгаж мэдээг дахин дахин шалгуулан гаргуулж байв.

Санал хураахад ирж чадаагүй өвчтэй буюу настан хүмүүсийн саналыг тусгай хүн мориор довтолгон явуулж саналыг нь авах ба санал хураах хуудас дээр гарын үсгийг зүүрж чадахгүй хүмүүс нь эрхий хурууны хээг дарж байх заавартай байв.

1945 оны 10 дугаар сарын 20-ны өдөр газар бүр БНМАУ-ын төрийн далбаа мандаж, хөгшин хөвөө, эрэгтэй, эмэгтэй, насанд хүрсэн хүмүүс цөм өглөөний зургаан цагт тогтоосон газраа цугларан саналаа өгч, дүнг баг, суманд үдийн 12 цаг хүртэл, аймгийн төвд оройн найман цаг хүртэл гаргаж дуусгахаар ажиллав.

Хоёр аймгийн санал хураалтын мэдээг гаргахаар олон нягтлан бодох сампин цохиж, түрүүчийн мэдээг давхар давхар шалган ажиллаж арай чамай анхны мэдээ 100 хувь болов гэж байтал Төв комиссын дарга Бумцэнд гуай одоо мэдээгээ ирүүлэхийг Улаанбаатараас утсаар шаардаж байна гэж аймгийн холбооны газрын дарга над дээр сандран гүйж ирэв.

Би урьдчилсан мэдээг өгөхөөр өөрөө холбоон дээр очиж утсаар ярих гэж “байна уу”, “дуулж байна уу, сонсож байна уу” гэж хоолойгоо сөөтөл хашгирсаар холбооны яаман дээр сууж байсан хариуцлагатанд мэдээгээ орой есөн цагийн үед өгч шөнийн 12 цагаас өмнө эцсийнхээ лавтай мэдээг Төв комисст утсаар илтгэж, өөрөө хоёр аймгийн үндсэн материалын эхийг авч хүргэхээр шөнө явна гэдгээ хэлэв.

Би олон сампинч нар, шалгах хүмүүсийн гараар давхар давхар шүүгдсэн, нотолгоо бүхий дүгнэлт мэдээгээ бүх материалын хамт авч Баянхонгороос гарч, Өвөрхангайг дайран мөн аймгийн мэдээ, материалыг авч Улаанбаатар руу явахад машины гөлгөр дугуй хэд хэдэн удаа цоорч, хэсэг зуур саатсаар ирж төв комиссын аппаратад бүх материалыг гардуулан, баримт бичигт гарын үсгээ зурж Бумцэнд гуайн гэрт утасдан танилцуулав.

Тэр 20-ны шөнийн 12 цагийн хавьд гарсан улсын хэмжээний мэдээнээс үзвэл улс даяар гарсан санал хураалтын ажил 100 хувь болсон баяртай мэдээг

дуулав. Санал хураалтыг ажиглахаар Гоминдааны засгийн газрын албан ёсны төлөөлөгч, Дотоод яамны орлогч сайд Ли Фин Цзянь тэргүүтэй хятад хүмүүс Улаанбаатарт хүрэлцэн ирж санал хураалт болж байсан хотын зарим газраар явж танилцаад, монголын ард түмэн төрийнхөө тусгаар тогтнолын талаар нэгдмэл нэгэн хүсэл эрмэлзлэлтэй байгааг үзэж нутагтаа буцсан юм. Энэ санал хураалтын дүнг Төв комиссын орлогч Ч.Сүрэнжав тэргүүтэй БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгчид Гоминдааны засгийн газар хүргэн өгч танилцуулсан билээ.

Гоминдааны засгийн газар уг мэдээтэй 1946 оны эхээр танилцан тус улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч хоёр улсын хооронд дипломат харилцаа 1946 оны 12 дугаар сарын 13-нд тогтоов.

**Б.Ширэндэв**  
**/Далайн давалгаагаар номоос**  
**Улаанбаатар хот .1993 он/**